



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ЖИНСТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2022 оны 03 сарын 01 өдөр

Дугаар А/20

Бодь

Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтийг  
хангаж ажиллах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2, 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1, 17.2.6, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.1, Эрүүл ахуйн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хог хаягдлын үнэ тарифыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар батлагдаж мөрдөж байгаатай холбогдуулан дагалдах журмыг 1 дүгээр хавсралтаар, Хог хаягдлын менежментийг сайжруулах төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар, хэрэгжилтийг хангаж ажиллах ажлын хэсгийг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Хог хаягдлын төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, тайлан мэдээг нэгтгэн үр дүнг тооцож ажиллахыг ажлын хэсэг, Байгаль орчны хяналтын Улсын байцаагч (С.Ганцэцэг)-д үүрэг болгосугай.

3.Менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан хөрөнгийг холбогдох төсвийн эх үүсвэрээс зарцуулахыг албан байгууллагын дарга эрхлэгч, нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, Засаг даргын орлогч (Н.Сумъяа)-д даалгасугай.

ДАРГА

Р.БАТЖАРГАЛ

